



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 31,628,000.00 (Гучин нэгэн сая зургаан зуун хорин найман мянган төгрөг) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал Б.Очирбат, “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

Бүртгэлтэй №2983

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд
 "Хөвсгөл АЗЗА" ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/		Үлдэгдэл өртөг
					Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	
1	Ниссан экстрел /Nissan Xtrail/ УБП 54-03, суудлын, хөдөлгүүр: 076912 арал: NT30-026617	2001/2008	181600	16,628,000.00	16,628,000.00	0.00	0.00
2	Тоёото Марк 2 /Toyota Mark 2/ УНК 41-81, суудлын, хөдөлгүүр: B2490 арал: JZX1106052898	2003/2011	102035	15,000,000.00	15,000,000.00	0.00	0.00
				31,628,000.00			
Нийт дүн				(Гучин нэгэн сая зургаан зуун хорин найман мянган)			